



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2а,
Утас: 32-01-26, Факс: (976-11) 31-93-35,
E-mail: info@erc.mn

2014.04.02 № 1/182

танай _____-ны № _____ т

Тогтоолын биелэлт хүргүүлэх тухай

УИХ-ын 2010 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” 72 дугаар тогтоолын Эрчим хүчний зохицуулах хорооны чиг үүрэгт хамаарах заалтуудын биелэлтийг гаргаж хавсралтаар хүргүүлэв. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 7 хуудас;

Хүндэтгэсэн,

ДАРГА



С.ОТГОНБАЯР

Зинэ 2014.04.22
тасар аах

2014.04.27.

УИХ-ЫН 2010 ОНЫ 72-Р ТОГТООЛЫН БИЕЛЭЛТ

1.1. Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай болон эрчим хүчний салбарын төрийн өмчийн компаниудын урт хугацаат зээлийг анх зээлсэн үеийн ханшаар тооцон төгрөгт шилжүүлэх, ханшийн зөрүүнээс үүсэх алдагдлыг Засгийн газар бүрэн хариуцаж тухайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцох, цаашид мөнхүү урт хугацаат зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг барагдуулах асуудлыг судлах;

2010 онд эрчим хүчний төрийн өмчит 11 компанийн урт хугацаат төслийн зээлийн дүн 324.14 тэрбум төгрөг хүрсэн байсан. Эдгээр компаниуд урт хугацаат зээлийн дүнг зээл анх авах үеийн Монгол банкны албан ханшаар тооцон төгрөгт шилжүүлэн өөрчилж, дамжуулан зээлдэх гэрээг 2012 онд Сангийн яамтай шинэчлэн байгуулсан. Зээлийн гэрээг шинэчилснээр зээлийн нийт дүн 243.7 тэрбум төгрөг болж, 2010 онтой харьцуулахад валютын ханшны зөрүүгээр 80.4 тэрбум төгрөгөөр буурсан. Эдгээр төрийн өмчит компаниуд урт хугацаат зээлийн валютын ханшны зөрүү болох 80.4 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтаар тооцон санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан байна. Мөн Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудын гадаадын урт хугацаат зээлийн дүн 24.7 тэрбум төгрөгөөр багассан байна.

**Эрчим хүчний төрийн өмчит компаниудын гадаадын
урт хугацаат зээлийн дүнгийн өөрчлөлт**

сая төгрөг

№	Компаниуд	УИХ-ын 72-р тогтоол хэрэгжилтийн		Зээлийн үлдэгдлийн бууралт
		Өмнөх үеийн зээлийн үлдэгдэл (2010 он)	Дараах үеийн зээлийн үлдэгдэл (2012:12:31)	
1	ДЦС 2 ТӨЖ	884.3	748.9	135.4
2	ДЦС 3 ТӨЖ	62,654.4	31,974.9	30,679.5
3	ДЦС 4 ТӨЖ	108,472.5	89,604.9	18,867.5
4	ДДЦС ТӨЖ	10,974.6	3,729.5	7,245.1
5	ЦДҮС ТӨЖ	26,155.8	24,975.6	1,180.3
6	УБЦТС ТӨЖ	34,545.2	30,221.8	4,323.4
7	УБДС ТӨЖ	40,167.6	32,324.9	7,842.7
8	ДҮТ ХХК	11,112.0	10,810.5	301.5
9	ДБЭХС ТӨЖ	20,459.7	12,750.3	7,709.4
10	ДзДЦС ТӨЖ	8,005.7	5,879.5	2,126.2
11	АУЭХС ТӨЖ	710.5	697.1	13.4
	НИЙТ ДҮН	324,142.3	243,717.8	80,424.4

**Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудын гадаадын
урт хугацаат зээлийн дүнгийн өөрчлөлт**

сая төгрөг

№	Нүүрсний уурхай	УИХ-ын 72-р тогтоол хэрэгжилтийн		Зээлийн үлдэгдлийн бууралт
		Өмнөх үеийн зээлийн үлдэгдэл (2010 он)	Дараах үеийн зээлийн үлдэгдэл (2012:12:31)	
1	Багануур ХК	58,546.1	44,559.0	13,987.1
2	Шивээ-Овоо ХК	72,262.2	61,519.7	10,742.5
	Дүн	130,808.3	106,078.7	24,729.6

1.2. Төвийн бүсийн эрчим хүчний компаниудад улсын төсвөөс олгож байгаа татаасын хэмжээгээр тухайн салбарын компаниуд болон нүүрсний уурхай хоорондын хуучин өр, авлагыг бүрэн хаах;

Төвийн бүсийн 5 дулааны цахилгаан станцад 2010 онд 11.96 тэрбум төгрөгийн, 2011 онд 12.4 тэрбум төгрөгийн татаасыг улсын төсвөөс тус тус олгосон бөгөөд энэхүү татаасаас Багануур, Шивээ-Овоо, Шарынгол зэрэг нүүрсний уурхайд 2010 онд 11.31 тэрбум төгрөгийг, 2011 онд 10.8 тэрбум төгрөгийг, 2010-2011 онуудад нийт 22.1 тэрбум төгрөгийг нүүрсний өр төлбөрт шууд төлж барагдуулсан болно.

2010 онд олгосон татаасаас нүүрсний өрийг барагдуулсан байдал, сая төгрөг

Компани	Улсын төсвөөс олгосон татаас	Үүнээс: Нүүрсний уурхайд төлөх өр төлбөрийг барагдуулахад				
		Багануур	Шивээ Овоо	Шарын гол	Бусад	Дүн
ДЦС-2	570.0	570.0				570.0
ДЦС-3	2,399.0	2,399.0				2,399.0
ДЦС-4	3,488.0	1,500.0	1,900.0			3,400.0
ДДЦС	2,164.0	950.0		1,014.0		1,964.0
ЭДЦС	3,335.0	1,185.5		1,550.0	240.0	2,975.5
Дүн	11,956.0	6,604.5	1,900.0	2,564.0	240.0	11,308.5

2011 онд олгосон татаасаас нүүрсний өрийг барагдуулсан байдал, сая төгрөг

Компани	Улсын төсвөөс олгосон татаас	Үүнээс: Нүүрсний уурхайд төлөх өр төлбөрийг барагдуулахад				
		Багануур	Шивээ Овоо	Шарын гол	Бусад	Дүн
ДЦС-2	1,080.0	1,080.0				1,080.0
ДЦС-3	2,980.1	2,630.5				2,630.5
ДЦС-4	3,738.0	2,321.1	1,416.9			3,738.0
ДДЦС	2,280.0	600.0		600.0	200.0	1,400.0
ЭДЦС	2,280.0	519.0		1,401.8		1,920.8
Дүн	12,358.1	7,150.6	1,416.9	2,001.8	200.0	10,769.3

1.3. Хэрэглэгчдэд ирэх ачааллыг хөнгөлөх зорилгоор 3 жилийн хугацаанд Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай болон төрийн өмчийн эрчим хүчний компаниудад улсын төсвөөс олгож байгаа татаасыг

бууруулахгүй байх, тарифын орлогоор санхүүжүүлэх боломжгүй өндөр өртөг бүхий томоохон шинэчлэлийн ажлуудыг улсын төсвөөс санхүүжүүлэх;

Эрчим хүчний салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг хэвийн найдвартай явуулах, дутагдаж буй орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Улсын төсвөөс 2010 онд 34.5 тэрбум, 2011 онд 42.4 тэрбум, 2012 онд 39.04 тэрбум, 2013 онд 34.0 тэрбум төгрөгийн татаасыг Төвийн бүсийн болон орон нутгийн эрчим хүчний компаниудад олгосон байна. Мөн 2010-2013 онуудад эрчим хүчний компаниудын томоохон засвар, шинэчлэлийн ажилд зориулж нийт 373.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Улсын төсвөөс олгосон* байна.

Эрчим хүчний салбарт Улсын төсвөөс олгосон татаас болон хөрөнгө оруулалт

тэрбум төгрөг

Санхүүжилт	2010 он	2011 он	2012 он	2013 он
Улсын төсвөөс олгосон татаас	34.5	42.4	39.0	34.0
<i>Үүнээс: Төвийн бүсийн эрчим хүчний компанид</i>	15.0	14.7	7.5	7.5
<i>Орон нутгийн эрчим хүчний компанид</i>	19.5	27.7	31.5	26.5
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьсан барилга байгууламж, хийгдсэн өргөтгөл, шинэчлэл*	42.1	62.0	148.4	120.7

**Тайлбар: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьсан барилга байгууламж, хийгдсэн өргөтгөл, шинэчлэлийн ажлын санхүүжилтийг Сангийн яамны цахим хуудсан дахь төлөвлөгөөнөөс авч тусгав.*

Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудад Улсын төсвөөс олгосон татаас

сая төгрөг

	Компани	2011 он	2012 он	Дүн
1	Багануур ХК	-	500.0	500.0
2	Шивээ-Овоо ХК	1,500.0	500.0	2,000.0

Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудад Улсаас хийсэн хөрөнгө оруулалт

	Хөрөнгө оруулалт	Он	Нийт мөнгөн дүн /тэрбум төг/	Тайлбар
Багануур ХК				
1	Экскаватор ЭКГ-10И-1ш, Херсний автосамосвал-2ш	2010	12.6	Монгол Улсыг хөгжүүлэх сангаас өгсөн урт хугацаат зээл
2	ЭШ-15/90 экскаваторын генератор-2ш	2011	1.4	Засгийн газрын хөрөнгө оруулалт
	Дүн		14.0	
Шивээ-Овоо ХК				
1	Автосамосвал САТ-773-2ш	2011	1.3	Засгийн газрын хөрөнгө оруулалт
	Нийт дүн		15.3	

1.4. Эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явцыг эрчимжүүлж, менежментийг сайжруулж, үйлдвэрлэл, дамжуулалт,

түгээлтийн үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардал хямдруулах, нүүрс боловсруулж ашиглах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

Эрчим хүчний компаниудын зардлын менежмент, үр ашгийн үзүүлэлтүүдийг сайжруулах зорилгоор Эрчим хүчний зохицуулах хороо нь 2010 онд “ДЦС-4”, “ДЦС-3”, “Эрдэнэтийн ДЦС”, “Эрдэнэт, Булганы ЦТС” зэрэг компаниудтай, 2011 онд “ДЦС-4”, “ДЦС-3”, “Дарханы ДЦС”, “Эрдэнэтийн ДЦС”, “Улаанбаатарын ЦТС”, “Багануур, зүүн өмнөд бүсийн ЦТС” зэрэг томоохон үйлдвэрлэгч, түгээгч компаниудтай “Гүйцэтгэлийн гэрээ”-г байгуулж ажиллалаа.

Дулааны цахилгаан станцуудтай байгуулсан Гүйцэтгэлийн гэрээнд станцын дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч, жишмэл түлшний хувийн зарцуулалтыг хэмнэх, үндсэн тоноглол /зуух, турбин/-уудын зогсолтын тоо, богино хугацаат өр төлбөрийг бууруулах зэрэг үзүүлэлтүүд орсон бол цахилгаан түгээх компаниудтай байгуулсан гэрээнд цахилгаан түгээлтийн алдагдлыг бууруулах, зах зээлийн Нэг худалдан авагчид төвлөрүүлэх орлогыг бүрэн төлөх, цахилгаан хангамжийн тасалдал, хэрэглэгчдэд дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчний хэмжээг өмнөх оноос бууруулах зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг оруулсан бөгөөд Гүйцэтгэлийн гэрээний үр дүнд дээрх компаниуд үйл ажиллагааны үзүүлэлтээ сайжруулж, тодорхой үр дүнд хүрсэн юм. Гүйцэтгэлийн гэрээний дагуу дээр дурьдсан компаниудын хүрсэн үр дүнд үндэслэн 2013 онд нийт **261.2 сая** төгрөгийн урамшууллыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэж компаниудад олгосон нь тэдгээрийн үр дүнтэй ажилласан ажилтнуудыг шагнаж урамшуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн юм.

№	Үр ашгийн үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2010 он	2011 он	2012 он	2013 он	
1	ДЦС-уудын дотоод хэрэгцээний цахилгааны зарцуулалт	хувь	15.62	15.14	14.86	14.56	
2	ДЦС-уудын жишмэл түлшний хувийн зарцуулалт	цахилгаанд	гр/кВт.ц	336.8	329.8	324.1	326.2
		дулаанд	кг/Гкал	178.6	179.0	178.1	178.8
3	Цахилгаан дамжуулалт, түгээлтийн нийт алдагдал	хувь	17.3	16.6	16.3	15.8	

Төвийн эрчим хүчний системийн хэмжээгээр 2013 онд цахилгаан станцуудын дотоод хэрэгцээнд зарцуулсан цахилгаан эрчим хүчний хэмжээг үйлдвэрлэсэн цахилгааны 14.56 %-д хүргэж бууруулснаар 2010-2013 онуудад 58.3 сая кВтц цахилгаан эрчим хүч буюу 4.9 тэрбум төгрөгийн, жишмэл түлшний хувийн зарцуулалтыг цахилгаанд 326.2 гр/кВтц болгож бууруулснаар 67.5 мянган тонн нүүрс буюу 1.21 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан байна. Түүнчлэн Дорнодын ДЦС дотоод хэрэгцээний цахилгаан болон түлшний зарцуулалтыг бууруулснаар 425 сая төгрөгийн хэмнэлт гаргажээ.

Мөн Нэгдсэн сүлжээний цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулснаар 2010-2013 онуудад Төвийн бүс дүнгээр 137.1 сая кВтц цахилгаан буюу үүнийг хэрэглэгчдэд борлуулах дундаж үнээр тооцоход 11.6 тэрбум гаруй төгрөгийн хэмнэлтийг, Баруун бүсийн эрчим хүчний системд 416 сая төгрөгийн, Дорнод бүсийн эрчим хүчний системд 94 сая төгрөгийн хэмнэлтийг тус тус бий болгожээ.

Ийнхүү эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үр ашгийг дээшлүүлснээр 2010-2013 онуудад нийт 18.6 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Хэдийгээр дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн хэдий ч эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явцыг эрчимжүүлж, менежментийг сайжруулах талаар дорвитой ажил хийгдэж чадаагүй болно.

1.5. Аймгуудын төв, түүний дотор тэргүүн ээлжинд шаардлагатай байгаа Ховд, Увс, Дорноговь, Сэлэнгэ болон Хөтөл тосгоны дулааны станц, дулааны шугам сүлжээний үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төрөөс дэмжлэг үзүүлэх, эсхүл концессын хуулийн дагуу хувийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах хувилбаруудыг судлан аль оновчтойг нь сонгох замаар техник, технологийн шинэчлэл хийх, боловсон хүчин, цалин хөлс, үнэ тарифын нэгдсэн бодлогоор хангах асуудлыг шийдвэрлэх;

Ховд, Увс, Дорноговь, Сэлэнгэ аймгуудын төвийн болон Хөтөлийн дулааны станцуудын дулааны эрчим хүч үйлдвэрлэлтийн бодит өртөг, үнэ тарифыг тогтоох зорилгоор Эрчим хүчний зохицуулах хороо нь 2011, 2012 онд ажлын хэсгийг газар дээр нь ажиллуулж, дүгнэлт гаргасан.

Аймгуудад мөрдөж буй тарифын харьцуулсан судалгааг хийж, цаашид хэрэглэгчдэд борлуулах үнэ тарифын талаар баримтлах чиглэлүүдийг тодорхойлон, аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлүүдэд зөвлөмж өгсөн.

Эдгээр аймгуудын хэрэглэгчдэд нэгдсэн үнэ тариф мөрдүүлэх нөхцөлд шаардагдах татаасын хэмжээг аймаг тус бүрээр гаргаж, дүгнэлт тооцоог тухайн үед Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд хүргүүлсэн.

1.6. Улсын төсвөөс татаас олгож байгаа хугацаанд ахуйн цахилгааны үнэ тарифыг шатлалтай болгон өрх бүрийн сарын хэрэглээний 150 кВт.ц-ийг одоогийн мөрдөж байгаа үнэ тарифыг индексжүүлэн тооцож, түүнээс дээшхи хэрэглээ болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ тарифыг бодит өртгөөр тооцох, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад чадлын тариф нэвтрүүлэх;

УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоол хэрэгжиж эхэлснээс хойш эрчим хүчний үнэ тарифт 2 удаа өөрчлөлт оруулаад байна. Үүнд:

2011 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс аж ахуйн нэгж, байгууллагад худалдах цахилгааны үнийг 10 хувиар, айл өрхийн цахилгааны үнийг 5 хувиар, дулааны эрчим хүчний үнийг 12 хувиар тус тус нэмэгдүүлж тогтоосон. Үүнээс гадна шинээр хэрэглэгчийн ангилал гаргаж, уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрт борлуулах цахилгааны үнийг энгийн аж ахуйн нэгжийн үнээс 14 хувиар өсгөн тогтоож байсан.

2013 оны 8 дугаар сарын 5-ны өдрөөс Төв, Дорнод, Алтай-Улиастай, Өмнөд бүсийн аж ахуйн нэгж, байгууллагын цахилгааны үнийг 20 хувиар, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрийн цахилгааны үнийг 30 хувиар, айл өрхийн цахилгааны үнийг 150 кВт.ц хүртэл хэрэглээнд тухайн үед мөрдөж байсан дундаж үнийг 6.7 хувиар өсгөж 79 төгрөг, 150 кВт.ц-аас дээш хэрэглээнд 21.5 хувиар өсгөж 96.6 төгрөгөөр тус тус тогтоосон. Харин дулааны эрчим хүчний үнийг өөрчлөөгүй ба дулааны үйлчилгээний тарифыг айл өрхийн орон сууцны талбайн хэмжээнээс хамааруулан 3000, 5000, 10000 төгрөг/сар-өөр тогтоон мөрдүүлж эхлээд байна.

Тогтоолын энэ заалтын гол агуулга болох 150 кВт.ц-ийн тарифыг индексжүүлэх, түүнээс дээшхи хэрэглээ болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ тарифыг бодит өртгөөр тооцох, үйлдвэр аж ахуйн

нэгж байгууллагад чадлын тариф нэвтрүүлэх ажлуудыг хэрэгжүүлэх талаар судалгаа, тооцоонуудыг Эрчим хүчний зохицуулах хороо 2013 оны хагас жилээс эхлээд байгаа болно. Эрчим хүчний өртөг зардалд нөлөөлж буй макро эдийн засгийн нөлөөллийн үзүүлэлтийг тодорхойлох судалгаа, үйлдвэр, аж ахуйн нэгжид чадлын тариф мөрдүүлэх ажлын хүрээнд төвийн бүсийн эрчим хүчний системийн хэмжээнд 39900 гаруй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, эрчим хүчний хэрэглээ, цахилгаан хангамжийн схем, хэрэглээний чадлын түвшин, тоолууржилтын байдал болон системд үзүүлж буй ачааллын судалгааг хийж, ангилал тогтоон, цахилгааны чадлын тариф тооцох аргачлал боловсруулах ажил хийгдэж байна. Харин ахуйн хэрэглэгчдийн дулааны тогтмол тарифыг 2013 оны 8-р сараас мөрдүүлж эхлээд байна.

1.7. Эрчим хүчний салбарын компаниудыг 2014 оноос эхлэн Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.1, 26.2.5-д заасны дагуу зах зээлийн зарчимд шилжүүлэн ажиллуулах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх;

2012 онд эрчим хүчний салбар нийт үйл ажиллагааны зардлын 84.9 хувийг тарифын орлогоор нөхөж ажиллан, үндсэн үйл ажиллагаандаа 66.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Улсын төсвийн татаасаар үйл ажиллагааны зардлын 6.8 хувийг нөхөж, санхүүгийн тайлан тэнцлээр нийт 37.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол 2013 онд үйл ажиллагааны зардлын 86,6 хувийг тарифын орлогоор, 3,9 хувийг улсын төсвийн татаасаар нөхөж үндсэн үйл ажиллагаандаа 65,4 тэрбум төгрөгийн, санхүүгийн тайлан тэнцлээр 34,5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаа.

Сангийн сайдын тушаалаар эрчим хүчний компаниуд 2007-2009 онуудад үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийснээр үндсэн хөрөнгийн хэмжээ 2.8 дахин өссөн нь элэгдлийн зардлыг их хэмжээгээр нэмэгдүүлсэн. 2012 оны гүйцэтгэлээр эрчим хүчний компаниуд нийт 97.6 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалтай ажилласан ба тарифын зохицуулалтаар үндсэн хөрөнгийн элэгдэл 2010 онд 60.3 тэрбум төгрөгөөр буюу 74 %-иар, 2011 онд 76.7 тэрбум төгрөгөөр буюу 94 %-иар тарифт тооцогдож байсан бол 2013 оны тарифын зохицуулалтаар 2012 оны санхүүгийн тайлан тэнцэлд туссан үндсэн хөрөнгөд ногдох дүнгээр элэгдлийн зардал болон цалингийн зардлыг тарифт 100 %-иар бүрэн тусгасан.

Эрчим хүчний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор шинээр хэрэгжүүлэх төслүүдийн тарифын тооцоонд хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцож байна. Тухайлбал, “Салхит”, “Оюутолгой”, “Сайншанд” салхин паркууд, “Айдынер глобал”, “АБ Солар винд” компанийн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх тарифт хөрөнгө оруулалтын өгөөжийг олон улсын жишгийн дагуу тооцож, тарифыг баталсан. Үүний дүнд 50 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай “Салхит” салхин цахилгаан станц 2013 оны 6-р сараас ашиглалтад ороод байна.

1.8. Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгааны түгээх сүлжээг бүрэн шинэчилж, өвлийн улиралд шөнийн цагаар ахуйн цахилгааны хэрэглээний үнэ, тарифыг “0” төгрөгт шилжүүлэх талаар бодлого боловсруулах;

Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд

цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох журам"-ын 2.3 дахь заалтыг үндэслэн Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлах айл өрхийн өвлийн улирлын шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны үнийг 50 хувиар бууруулан тооцож байна.

“Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай” Монгол улсын хуулийг хэрэгжүүлэх, цахилгааны үнийн хөнгөлөлт олгох журам боловсруулах, хөнгөлөлтөд хамруулах айл өрхийн тоо, үнийн хөнгөлөлтөд зарцуулах хөрөнгийн тооцоог хийж, жил бүр тодорхой эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулж байна.

2012-2013 оны халаалтын улиралд Улаанбаатар хотод түлшний хөнгөлөлтөөр 45,822 хэрэглэгч, халаагуурын хөнгөлөлтөөр 1,924 хэрэглэгч, нийт 47,746 хэрэглэгч “Цахилгааны үнийн урамшуулал олгох гэрээ” байгуулан үнийн хөнгөлөлт эдэлж байгаа бөгөөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулалд 2011-2012 онуудад 1,339.95 сая төгрөг, 2013 онд 2,685.43 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгааны үнийн урамшуулал олгох журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус урамшуулалд айл өрхийг хэн, хэрхэн тодорхойлох, хамруулах болон бусад асуудлыг тодорхой тайлбарласан “Хэрэглэгчдэд зориулсан зөвлөмж” бэлтгэж олон нийтийн хүртээл болгов.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО